



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 4-р сарын 29-өөс
5-р сарын 8-ны байдлаар

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 4-р сарын 29-өөс 5-р сарын 8-ны байдлаар

КОВИД-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулах чиглэлд улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн гаргаж буй гадаад орчны тойм мэдээллийн найм дахь дугаарыг хүргэж байгааг хүлээн авна уу.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ


- АНУ-ын Конгрессын судалгааны төвөөс 5-р сарын 1-нд нийтэлсэн судалгааны тайланд цаашид нөхцөл байдал энэ хэвээр үргэлжилбэл **КОВИД-19-ийн нөлөөгөөр сар бүр дэлхийн эдийн засгийн өсөлт 2 нэгж хувиар буурах**, эдийн засгийн уналт хэр гүнзгий байхаас шалтгаалан **олон улсын худалдаа глобал түвшинд 13-32 хувиар агшина** гэсэн төсөөлөл гаргажээ.
- АНУ-ын ажилгүйдлийн түвшин 3-р сард 4.4 хувь байсан бол **4-р сард 14.7 хувь болж нэмэгджээ**. Блүүмбергийн шинжээчдийн тооцсон эдийн засгийн сэргэлтийн дохиологч индикаторууд (Recovery tracker) АНУ-ын эдийн засаг 4-р сард огцом муудаж, 5-р сарын эхний 7 хоногт эдийн засгийн уналт үргэлжилсэн хэвээр байгааг харуулж байна. **АНУ-ын эдийн засаг энэ оны II улиралд 30-аас их хувиар** буюу Их хямралын үеэс хойш байгаагүйгээр агшина гэсэн шинжээчдийн таамаг өөрчлөгдөөгүй хэвээр байна. 1930 онд тохиосон Их хямрал нийт 3 жил үргэлжилсэн бөгөөд эдийн засаг бүрэн сэргэхэд 10 гаруй жил зарцуулсан байна. АНУ өнгөрсөн сард 2.2 их наяд ам.доллартай тэнцэх хямралын эсрэг багцыг баталсан бөгөөд Холбооны нөөцийн банк (ХНБ) энэ онд дор хаяж 5 их наяд ам.долларыг эдийн засагт нийлүүлэх хүлээлттэй байна.
- Евростатын урьдчилсан тооцоогоор **Евро бүсийн эдийн засаг I улиралд өмнөх улирлаас 3.8 хувиар** агшжээ. Энэ нь 2008-09 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын үеэс ч илүү гүнзгий уналт юм. Европын Төв банкны Ерөнхийлөгч Кристин Лагард Европын Холбооны удирдагчдад Евро бүсийн эдийн засгийн уналт II улиралд улам гүнзгийрч, **Евро бүсийн ДНБ энэ онд 5-12 хувиар агшихаар байгааг** анхааруулжээ. Европын комиссын 5-р сарын 6-ны өдөр шинэчилсэн суурь төсөөллөөр Евро бүсийн эдийн засаг 2020 онд 7.7 хувиар агшиж, 2021 онд 6.2 хувиар өсөх төсөөллийг зарлав. Евро бүсийн ажилгүйдлийн түвшин энэ онд 9.5 хувьд хүрч өсөх, инфляц 0.2 хувь болж буурах хүлээлттэй байна. Европын төв банк арилжааны банкуудад олгодог урт хугацаатай зээлийн хүүг бууруулсан бөгөөд тодорхой нөхцөлтэйгөөр зарим банкуудад -1 хувь хүртэл хасах хүүтэй зээл олгохоо мэдэгдлээ. Ийнхүү банкуудын эх үүсвэрийг нэмэгдүүлснээр бизнесийн зээлийн урсгалыг

тасалдуулалгүй, ажлын байрыг хамгаалахыг зорьж байна.

- **Европын бизнес болон хэрэглэгчийн итгэлийн индекс 4-р сард түүхэн доод түвшинд хүрэв.** Тухайлбал, Европын холбооны эдийн засгийн нөхцөл байдлыг илтгэх нэгдсэн индикатор 4-р сард 28.8 нэгж хувиар буурч, 65.8 болжээ. Тус индикаторт КОВИД-19 цар тахал хүчтэй дэгдсэн Итали улсын эдийн засгийн үзүүлэлтийг хамруулах боломжгүй байсан тул бодит байдалд үүнээс ч ихээр унасан байх магадлалтай гэж Европын Комисс үзэж байна¹.
- **ОХУ-ын татварын орлого 4-р сард 30 хувиар буурчээ.** “Continuum Economics”-с ОХУ, Турк, Өмнөд Африк зэрэг улсуудын эдийн засгийн төсөөлөл, шинжилгээг шинэчлэв². ОХУ болон Турк улсад цар тахал эрчтэй тархаад байгаа бөгөөд эдийн засаг нь хэр хурдан сэргэх нь улсуудын (i) эрүүл мэндийн салбарын бэлэн байдал, хангамж, (ii) КОВИД-19 цар тахлаас өмнөх эдийн засгийн нөхцөл байдал, (iii) хэрэгжүүлж буй мөнгөний болон төсвийн бодлого зэрэг хүчин зүйлээс хамаарахаар байна. Улс орнуудын эдийн засгийн өсөлтийг хэмжихдээ хөл хорионоос үүдэлтэй дотоод шокуудыг л тооцжээ. Хэрэв хөл хорионоос үүдэлтэй гадаад шокуудыг нэмбэл ДНБ нэмээд 1.1-1.3 дахин буурахаар байна. Тооцооноос харахад **Турк улсын хувьд цар тахлаас өмнөх эдийн засгийн байдал харьцангуй сайн байсан бол дээр дурдсан (i) болон (iii) хүчин зүйлс хангалтгүй байгаа тул 2020 онд эдийн засаг нь 2.5 хувиар агшихаар хүлээгдэж байна.**

ОХУ-ын хувьд дээр дурдсан (i) болон (ii) хүчин зүйлс сайн байгаа боловч, мөнгөний болон төсвийн бодлогоос шалтгаалж эдийн засаг нь 2020 онд 3.5 хувиар агших төсөөлөлтэй байгааг тус байгууллагаас мэдээлжээ.

- **Зүүн-Өмнөд Азийн орнуудын аж үйлдвэрлэлийн PMI индекс 4-р сард түүхэн доод түвшинд хүрэв.**



Үүнд Индонез, Малайз, Вьетнам, Филиппин улсуудын аж үйлдвэрлэлийн PMI индексүүд 4-р сард түүхэн доод түвшинд хүрсэн бол, Өмнөд Солонгос, Тайвань, Японы PMI индексүүд 2009 оноос хойшхи хамгийн доод түвшинд хүрчээ. Энэтхэгийн үйлчилгээний PMI индекс 4-р сард 43.9 нэгжээр буурч 5.4-тэй гарсан нь дэлхийн аль ч оронд ажиглагдаагүй доод түвшин юм. КОВИД-19 цар тахлын тархалт олон улсад үргэлжилж, Хятадын гадаад эрэлт буурах нөлөөгөөр Ази тивийн аж үйлдвэрлэл II улиралд буурах төлөвтэй байна. Өмнөд Солонгосын эдийн засгийн сэргэлт удаашрах хандлагатай боллоо. Тухайлбал, Өмнөд Солонгосын экспорт 3-р сард өсөлтгүй байсан бол 4-р сард жилийн 24.3 хувиар буурсан нь гадаад эрэлт огцом буурсныг илтгэж байна.

¹ European Commission: [Spring 2020 Economic Forecast - A deep and uneven recession, an uncertain recovery](#)


² Continuum Economics: [COVID-19, Asia's Q2 Disappointments Begin](#)

2 ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **Хятадын эдийн засаг 4-р сарын 28-ны өдрийн байдлаар 91.3 хувийн потенциал түвшинд ажиллаж байна³.** Хэдийгээр ажил эрхлэлт болон үйлдвэрүүдийн үйл ажиллагаа хэвийн үеийн түвшинд хүрсэн ч, гадаад эрэлт саарсан, дотоод эрэлт төдийлөн нэмэгдэхгүй байгаа тул гадаад худалдаа эрхэлдэг жижиг ААН-үүд хүндрэлтэй нөхцөл байдалтай хэвээр байна.
- **БНХАУ-д КОВИД-19-ийн шинэ тохиолдлын тоо 5-р сарын 1-ний байдлаар 116-гаас 60 хүрч буурсан тул олон нийтийн болгоомжлол багасч, дотоод эрэлт нэмэгдэнэ** гэж Блүүмбергийн шинжээчид хүлээж байна. Автомашинь худалдаа 4-р сарын 24-ны байдлаар өмнөх долоо хоногоос нэмэгдсэн нь Засгийн газраас өгч буй дэмжлэг татаас нөлөөлж байна.
- **4-р сард Хятадын экспорт 3.5 хувиар өсч, импорт 14.2 хувиар агшжээ⁴.** Экспорт хүлээлтээс өндөр өсөлттэй гарсан нь Зүүн Өмнөд Азийн орнууд руу экспортлох бараа, бүтээгдэхүүн эхний 4 сард 3.9 хувиар нэмэгдсэнтэй холбоотой бол, харин АНУ, Евро бүс рүү гаргасан экспорт оны эхний 4 сард 15.9% болон 6.6%-аар тус тус буурчээ. БНХАУ-ын АНУ-аас авсан импорт мөн хугацаанд 3 хувиар буурсан. Импортын тоо, хэмжээ нэмэгдсэн ч, түүхий эдийн үнэ буурснаар нийт экспорт буурчээ. Дэлхий нийтэд хөл хорио нэмэгдсэн нөлөөгөөр зарим цахилгаан барааны эрэлт алгуур нэмэгдсэн нь экспортыг дэмжлээ гэж Австрали болон Шинэ Зеландын Банкны группийн БНХАУ-ыг хариуцсан

шинжээчид дүгнэв. Гэвч Хятадын экспортын өсөлт нь түр зуурын шинжтэй байгаа бөгөөд дэлхий нийтийн эрэлт буурах үед буюу ирэх саруудад Хятадын экспорт агших таамаглалтай байна.

- **1-р улиралд БНХАУ-ын Монгол Улсаас импортлосон коксжих нүүрсний хэмжээ 2.73 сая тонн буюу өмнөх оны мөн үеэс 60 хувиар буурсан бол Австралиас импортлосон коксжих нүүрсний хэмжээ 91 хувиар нэмэгдэж 14.7 сая тоннд, ОХУ-аас импортлосон коксжих нүүрсний хэмжээ 15.3 хувиар өсч, 1.32 сая тоннд хүрчээ.**



Австралийн “South 32” уурхайн үйлдвэрлэл 1-р улиралд 1.17 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 3 хувиар буурсан бол өмнөх улирлаас 17.9 хувиар нэмэгдсэн байна. Тус компанийн улирлын тайланд оны эхний улиралд нүүрсний үйлдвэрлэл КОВИД-19-тэй холбоотойгоор тасалдаагүй гэж мэдээлэв.

- **Хятадын төмрийн хүдрийн импорт 1-р улиралд нийт 262.7 сая тонн буюу өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар нэмэгдсэн хэдий ч, зөвхөн 3-р сард 85.9**

³ Энэ индекс нь Хятадын 50 хотуудын гео-байршлын мэдээлэл дээр үндэслэн ДНБ-ээр жигнэгдсэн тооцоолол болно.

⁴ Блүүмбергийн шинжээчид БНХАУ-ын экспорт 4-р сард 11 хувиар агших, импорт 10 хувиар агшихаар хүлээж байсан юм.

сая тонн байсан нь өмнөх оны мөн үеэс **0.6 хувиар буурсан үзүүлэлт юм.**

- КОВИД-19 өвчлөлөөс шалтгаалан эрэлт төдийлөн нэмэгдэхээргүй байгаа тул **коксжих нүүрсний дэлхийн зах зээл дээрх үнэ болон Хятадын эрчим хүчний нүүрсний үнэ бага түвшинд хадгалагдсан хэвээр байгааг SxCoal 4-р сарын тайландаа мэдээлэв.** Энэ оны 2-р улиралд дэд бүтцийн төслүүд эхэлснээр, гангийн эрэлт нэмэгдэж Хятадын гангийн жилийн үйлдвэрлэл өмнөх оны түвшинд хүрэх хүлээлттэй байна. Сүүлийн 2 сар дараалан буурч буй коксжих нүүрсний үнийг дэмжих хүрээнд Хятадын зарим боомтууд нүүрсний импортын хоригоо чангаруулаад байгаа бөгөөд зөвхөн худалдан авагч тал гаалийн хуудас бөглөснөөр тээврийг хүлээн авах боломжтой болсон гэж SxCoal мэдээлэв ⁵. Мөн БНХАУ-ын Засгийн газраас нүүрсний үнийг дэмжих зорилгоор үйлдвэрүүдийг үйлдвэрлэлээ сайн дураараа бууруулахыг уриалж байна. Жингтанг боомт дээрх импортын коксжих нүүрсний нөөц 0.32 сая тонноор буурч, 3.3 сая тоннд хүрснээр нөөц 6 дахь долоо хоногтоо буурав.
- Автомашины худалдаа оны эхний 3 сард 3.67 сая нэгжид хүрч, өмнөх оны үеэс 42.4 хувиар буурсан бол автомашины үйлдвэрлэл эхний 3 сард 3.47 сая нэгжид хүрч 44.6 хувиар буурсан байна. Харин автомашины худалдааны уналт 3-р сараас саарч, 1.43 сая нэгж борлуулагдсанаар өмнөх сартай харьцуулахад 361.3 хувиар өсөв.
- **Хятадын дотоодын үл хөдлөх хөрөнгө дэх хөрөнгө оруулалт** оны эхний 3 сард 1.012 их наяд юань хүрч, өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар буурсан хэдий ч,

цаашид алгуур сэргэх хүлээлттэй байна. Хятадын Хөгжил Шинэтгэлийн Хороо 2 болон 3-р сард нийт 189.8 тэрбум юанийн дэд бүтцийн төслүүдийг баталсан нь өмнөх оны мөн үе (32.3 тэрбум юань)-тэй харьцуулахад эрс өссөн үзүүлэлт байв.

- КОВИД-19 өвчлөлийн тодорхой бус байдалтай холбоотойгоор БНХАУ-ын тэргүүн энэ жил нэрлэсэн ДНБ-ий өсөлтийн хувийг зарлахгүй байх өөрчлөлтийг оруулах магадлалтай байна. Энэ талаар Хятадын Ардын Их Хурлаар хэлэлцэх юм.
- **Хятадын төсвийн бодлого:** Төсвийн бодлогын хүрээнд тусгай зориулалттай Засгийн газрын бондын арилжаа болон орон нутагт олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг авснаар 2020 онд Хятадын Засгийн газар 4-5 их наяд юанийн төсвийн зарцуулалт хийх төлөвтэй байна. **Хятадын Ардын Их Хурлын тов зарлагдаж, 5-р сарын 22-ны өдөр хуралдахаар боллоо.** Энэ нь Хятадын Засгийн газар КОВИД-19 өвчлөлийн тархалтыг бүрэн хяналтдаа оруулах, эдийн засаг оны 2-р хагаст “V” хэлбэртэй сэргэлт бий болох боломжтой гэсэн эерэг дохио болж байна.
- **Хятадын мөнгөний бодлого:** Хятадын Ардын Банк (ХАБ) энэ онд бодлогын хүүгээ 0.3-0.4 нэгж хувиар бууруулахаар байгаа бөгөөд 2-р сараас хойш бодлогын хүүг 0.3 нэгж хувиар бууруулж нэг жилийн хугацаатай дунд хугацааны зээлийн хүүг (TMLF) 3.15 хувиас бууруулж 2.95 хувьд хүргээд байна.
- Цаашид дунд хугацааны зээлийн хүүг бууруулах, жижиг дунд бизнесүүдэд хөнгөлөлттэй зээлийн нөхцөлийг дэмжих зэрэг арга хэмжээг авах хүлээлттэй байна.

⁵ SxCoal: [Search Results Web results China further tightens grips on coking coal imports](#)

3 ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ГОЛЛОХ ИНДЕКС ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ

USD, Dow Jones, S&P:

- ХНБ-аас актив худалдан авалтаа үргэлжлүүлэн, зах зээлийн хөрвөх чадвар буурахаас сэргийлж мөнгө нийлүүлсээр байна.
- ЗГ-ын зүгээс төсвийн удаа дараагийн дэмжлэг үзүүлж буй нь хөрөнгийн зах зээлд эерэг дохио болсноор хувьцааны индексүүд өмнөх сараас 14-19%-иар сэргэлээ.
- АНУ-ын эдийн засаг 2020 оны I улиралд 4.8%-иар агшаад байна.
- АНУ-д Ковид-19 вирусийн тархалт эрчимжиж олон мужид хөл хорио тогтоосон нь хувьцааны ханш 3 дугаар сард огцом унах нөхцөл байдлыг үүсгэв. Энэ огцом уналтыг ашиглан дэлхийн томоохон сангууд болох Норвегийн баялгийн сан, Саудын Арабын Нийтийн хөрөнгө оруулалтын сан АНУ-ын хөрөнгийн биржид бүртгэлтэй томоохон компаниудын хувьцааг их хэмжээгээр худалдан авсан байна.

EUR:

- Европын төв банкны Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг хэвээр хадгалах шийдвэр гаргав. Өнгөрсөн 7 хоногт евро ам.долларын эсрэг 1.3%-иар суларч, 1.08 түвшинд хүрэв.
- Ам.долларын ханш голлох валютуудын эсрэг чангарсан бөгөөд Евро бүсийн ихэнх улс, хотуудад хөл хорио тогтоосон хэвээр байгаа нь еврогийн ханшид сөргөөр нөлөөлөв.

CNY:

- Юань ам.долларын эсрэг чангарч, 7.07 түвшинд хүрлээ.
- Хөрвөх чадварыг хангах үүднээс ХАБ-ны зүгээс юанийн ханшийн хэлбэлзлийг нам дор байлгахыг зорьж байна.
- БНХАУ-ын эдийн засгийн үйл ажиллагаа сэргэж эхэлснээр хувьцааны индекс сарын өмнөх үеэс 1.5%-иар өслөө.

JPY, Nikkei:

- Японы төв банкны Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг -0.1 түвшинд хэвээр хадгалах шийдвэр гаргав. Мөнгөний бодлогын хорооноос ЗГҮЦ худалдан авах дээд хязгаарт тодорхой хязгаар тавиагүй нь энэ удаагийн мөнгөний бодлогын шийдвэрт гарсан томоохон өөрчлөлт болов.
- Өнгөрсөн 7 хоногийн хугацаанд Иен ам.долларын эсрэг 0.4%-иар суларч 106.68-д хүрэв.

GBP, FTSE:

- Фунт стерлинг нь ам.долларын эсрэг суларч, 1.24 түвшинд хүрлээ.
- Тайлант хугацаанд ам.долларын ханш чангарсан, Их Британи Улсад Ковид-19 вирусийн нөхцөл байдал сайжрахгүй байгаа нь ханшид сөргөөр нөлөөллөө.

4 ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

	Бодит гүйцэтгэл						Товч тайлбар
	Үнэ 2020/05/05	Өөрчлөлт					
		өдрийн	7 хоног	сарын	оны эхнээс	жилийн	
Зэс	5127	0.8%	-1.3%	6.1%	-16.2%	-16.2%	КОВИД-19-ийн тархалт АНУ, Евро бүсийн орнуудад нэмэгдсэн нөлөөгөөр зэсийн эрэлт саарахаар байна. Гэсэн хэдий ч Хятадын үйлдвэрлэлийн салбар 91%-ийн потенциалгаар ажиллаж байна гэсэн мэдээ үнэ өмнөх сараас бага зэрэг нэмэгдэхэд голлон нөлөөлөв.
Кокс-нүүрс	113.3	-	-	-	-	-65.2%	КОВИД-19-ийн нөлөөгөөр эрэлт нэмж буурах төлөвтэй байгаа. Хятадын голлох цахилгаан станцуудын нөөц 31 өдрийн хэрэгцээг хангах хэмжээнд хүрч нэмэгдсэн ба Австралийн нийлүүлэлт тогтвортой байна.
Төмөр-хүдэр	82.5	0.0%	-0.4%	2.4%	-10.8%	-6.2%	Хятадын аж үйлдвэрлэлийн эрэлт буурахаар байгаа ч алгуур сэргэх хүлээлттэй байгаа бол нийлүүлэлтийн хувьд талаас илүүг бүрдүүлдэг Австралийн үйлдвэрлэл тогтвортой байна.
Алт	1705.9	-1.2%	-1.6%	1.5%	10.3%	31.6%	Дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал давамгайлж байгаа тул аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлт нэмэгдэхээр байна.
Газрын тос (Брент)	30.9	-4.0%	31.9%	-10.1%	-55.1%	-58.3%	КОВИД-19-ийн нөлөөгөөр эрэлт огцом буурч, Сауди Араб, ОХУ-ын үйлдвэрлэлээ нэмэгдүүлэхээр байсан бол ОПЕК-ийн нэгдэл нийлүүлэлтээ 2020 он дуустал бууруулахаар болсон нөлөөгөөр үнэ өмнөх долоо хоногоос нэмэгдэхэд голлон нөлөөлөв.